

2022 оны 12 сарын 31

**БӨХӨГ ХК-ИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН  
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

АЯА ТАКС АУДИТ ХХК

**БӨХӨГ ХК-ИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2022 ОНЫ 12 САРЫН 31**

**АГУУЛГА**

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ  
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**ХУУДАС**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1  
2  
3  
4  
5



AyaatAx

**АЯА ТАКС АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, СБД, I хороо, V хороолол,  
14251, Чингисийн өргөн чөлөө 19-Б Бизнес  
тауэр 11 давхар Утас: 99994447, 98658500

2023.03.21 № 23  
Танай \_\_\_\_\_ -ны № 107 -т

**БӨХӨГ ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД  
ТАНАА**

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН  
БОЛОН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**Дүгнэлт**

Бид БӨХӨГ ХК-ий 2022 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайланийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Санхүүгийн тайланда хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тайлант оны байдлаар авч үзэж дүгнэлт гаргасан болно.

а/ Бараа материалын үнэлгээ

Үдирдлага удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгыг тодорхойлоходоо үлэмж хэмжээний төсөөлөл болон үнэлэмж ашигладаг учраас бид бараа

материалын үнэлгээг аудитын гол асуудал гэж үзсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогоор бараа материалын үнэлгээг тооцохдоо бараа материалын наскилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон алдагдлын хувийг ашиглан тооцдог.

**Бараа материалын үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:**

- ❶ Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо ашигласан удирдлагын үнэлгээ болон бараа материалыг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл залруулж, бараа материалын сан байгуулах дотоод горимыг судлах, ойлгох;
- ❷ Борлуулалтын түүхэн мэдээ, өнөөгийн зах зээлийн орчин, маркетинг болон урамшууллын төлөвлөгөө, бараа материалын наскилт болон бараа материалын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн бараа материалын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- ❸ Түүврийн аргаар бараа материалын наскилтыг холбогдох анхан шатны баримттай нь тулгаж шалгах;
- ❹ Түүврийн аргаар бараа материалын борлуулалтын үнийг холбогдох анхан шатны баримттай тулгаж шалгах.

**Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:**

**б/ Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал**

- ❶ Удирдлагын авлагыг тооцоолдог горимыг судлах, ойлгох;
- ❷ Төлөгдөөгүй авлагын үлдэгдэлд байж болох боломжит эрсдлийн хэмжээг тооцоолох болон ойлгох зорилгоор түүврийн аргаар дансны ба бусад авлагын наскилтиг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулгаж шалгах;
- ❸ Төлөгдхөх хугацаа нь 60 хоногоос хэтэрсэн авлагууд нь даатгагдсан эсэхийг үнэлэхийн тулд даатгалын гэрээтэй нь тулгах, тайлант хугацааны дараа цуглуулагдсан дүнгүүдийг шалгах. Даатгагдаагүй авлагуудын хувьд, тухайн харилцагчдийн өмнөх жилүүдийн төлбөр төлсөн байдал зэрэгт үндэслэн найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- ❹ Тайлант хугацааны дараа цуглуулагдсан авлагыг холбогдох баримтуудтай тулгах;
- ❺ Түүврийн аргаар өмнөх жилүүдэд удирдлагын тооцоолсон найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой байсан эсэхийг төлөгдсөн авлага, бодит найдваргүй авлагын зардлыг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулган баталгаажуулах.

**в/ Татварын тооцооллын үнэн, зөв байдал**

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар

бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс шалтгаалсан татварын эрсдэл байсаар байна.

**Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:**

- ❶ Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;
- ❷ Татварын хууль, журам дүрэм болон практик туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланда бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;
- ❸ Санхүүгийн тайланда бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.

**Бусад мэдээлэл**

Энэхүү санхүүгийн тайланда өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед үнших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг үншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- ❶ Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- ❷ Санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх; эсвэл
- ❸ Түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг холбогдох эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид аудитлагдсан санхүүгийн тайлан болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авна.

### **Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлагын эрх Бүхий Этгээдийн Үүрэг**

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

### **Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг**

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

#### **Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- 💡 Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- 💡 Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- 💡 Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.



Я.Аюушжав  
Захирал  
Аяа Tax Аудит ХХК  
2023 оны 3-р сарын 2 /

**БӨХӨГ ХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 САРЫН 31**

*Аяа Такс Аудит ХХК*

<b>Үзүүлэлт</b>	<b>Тодруулга</b>	<b>2021</b>	<b>2022</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	2,540,600	11,496,900
Дансны авлага	6	60,690,800	60,690,800
Бараа материал	7	141,057,100	141,057,100
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	8	766,278,400	766,278,400
Үндсэн хөрөнгө	9	2,366,010,800	2,366,010,800
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>3,336,577,700</b>	<b>3,345,534,000</b>
Дансны өглөг	10	656,499,500	708,911,278
Цалингийн өглөг	11	26,090,600	26,090,600
Богино хугацаат зээл	12	79,491,700	79,491,700
Богино хугацаат өр төлбөр	13	833,724,400	833,724,400
Үүнээс: төсөөт төлөх	14	166,753,400	168,805,306
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>1,762,559,600</b>	<b>1,817,023,284</b>
Өмч хувьцаат	15	45,729,300	45,729,300
Эздийн өмчийн бусад хэсэг	16	1,962,373,300	1,962,373,300
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(434,084,500)	(479,591,884)
<b>Өмчийн нийт дүн</b>		<b>1,574,018,100</b>	<b>1,528,510,716</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,336,577,700</b>	<b>3,345,534,000</b>

**БӨХӨГ ХК ОРЛОГЫН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 САРЫН 31**

*Аяа Такс Аудит ХХК*

<b>Үзүүлэлт</b>	<b>Тодруулга</b>	<b>2022</b>
Борлуулалтын орлого (цэвэр)	17	16,800,000
Борлуулалтын өртөг		
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>16,800,000</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	18	62,307,384
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(45,507,384)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)		(45,507,384)
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал )		

**БӨХӨГ ХК ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 САРЫН 31**

<b>Аяа Такс Аудит ХХК</b>				
<b>Үзүүлэлт</b>	<b>Өмч</b>	<b>Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>НИЙТ ДҮН</b>
20... оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	45,729,300	1,962,373,300	(434,084,500)	1,574,018,100
Залруулсан үлдэгдэл	45,729,300	1,962,373,300	(434,084,500)	1,574,018,100
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	45,729,300	1,962,373,300	(434,084,500)	1,574,018,100
Залруулсан үлдэгдэл	45,729,300	1,962,373,300	(434,084,500)	1,574,018,100
Тайланы төслийн цэвэр ашиг алдагдал			(45,507,384)	(45,507,384)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	45,729,300	1,962,373,300	(479,591,884)	1,528,510,716

**БӨХӨГ ХК МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2022 ОНЫ 12 САРЫН 31**

<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>2022</b>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлогын дүн (+)	18,480,000
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого Мөнгөн зарлагын дүн (-)	18,480,000 52,842,244
Ажиллагчдад төлсөн Татварын байгууллагад төлсөн	4,063,200 46,365,944
Бусад мөнгөн зарлага Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлогын дүн (+)	2,413,100 (34,362,244) -
Хүлээн авсан хүүний орлого Мөнгөн зарлагын дүн (-)	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Мөнгөн орлогын дүн (+)	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Мөнгөн зарлагын дүн (-)	51,365,944 51,365,944 8,047,400
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн Бүх цэвэр мөнгөн гүйлгээ Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,047,400 43,318,544 8,956,300 2,540,600 11,496,900

**БӨХӨГ ХК САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2022 ОН**

**1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт**

БӨХӨГ ХК (цашид "Компани" гэх) нь 1996 онд, 235 гишүүнтэй, 1,615,372.6 мянган төгрөгийн дурмийн сантайгаар Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан. Компаний үндсэн үйл ажиллагааны чиглэл нь шувууны аж ахуй, шувууны мах өндөг бэлтгэх, борлуулах, газар тариалан эрхлэх, өвс малын тэжээл, түлээ нүүрс боловсруулах зах ажиллуулах болно.

2015 онд хувь нийлүүлэгч 3 нэмэгдэж, 5 хасагдан нийт 233 хувьцаа эзэмшигчдэй болж өөрийн хөрөнгийн хэмжээг 27,212.4 мянган төгрөгөөр хасагдаж 1,588,160.2 төгрөг болсныг үлсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

**ҮЦ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРААНГУЙ СУДАЛГАА**

Үнэт цас: 69-БӨХӨГ  
Бүртгэх одор : 2022-03-22  
Судалгаа гаргасан огноо : 3/25/2022

Зарласан ширхэг: 457,293  
Гаргасан ширхэг: 457,293  
Арилжаалагдаагүй ширхэг: 0  
Зорүү: 0

№	БДК код	БДК -ийн нэр	Тоо ширхэг	Хувьцаа эзэмшигчдийн тоо
1	2	МАСДАК УЦК ХХК	269	8
2	4	САНАР УЦК ХХК	281	6
3	5	ЗЭРГЭД УЦК ХХК	2,798	14
4	6	МЭРГЭНСАНАА УЦК ХХК	1,440	12
5	7	БИДИСЕК УЦК ХК	4,950	14
6	8	- Орчил инвест	1,797	9
7	10	АЛТАН ХОРОМСОГ УЦК ХХК	440	2
8	13	БҮЛГАН БРОКЕР УЦК ХХК	760	18
9	14	Ажтай инвест	40	1
10	15	ДАРХАН БРОКЕР УЦК ХХК	1	1
11	18	МОНСЕК УЦК ХХК	1,285	28
12	19	ТУЛГАТЧАНДМАНЬ БЯН УЦК ХХК	181	2
13	21	БҮМБАТ АЛТАЙ УЦК ХХК	17	1
14	22	АЗИА ПАСИФИК СЕКЮРИТИС УЦК ХХК	101	1
15	23	- Лог	10	1
16	25	ТАВАН БОГД УЦК ХХК	233	1
17	26	- Шанд эрдэнэ	4	1
18	27	АРГАЙ БЭСТ УЦК ХХК	554	7
19	29	- ДЭЛГЭРХАНГАЙ СЕКЮРИТИЗ УЦК ХХК	6,317	81
20	32	АРД СЕКЮРИТИЗ УЦК ХХК	424,585	9
21	32	ТЭНГЭР КАПИТАЛ УЦК ХХК	1	1
22	57	- Өлзий Энд Ко КАПИТАЛ УЦК ХХК	45	2
23	58	МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС УЦК ХХК	20	1
24	69	"Эм Даблью Ти Эс УЦК" ХХК	20	1
25	71	ТИ ДИ БИ СЕКЮРИТИС УЦК ХХК	1	1
26	78	АПЕКС КАПИТАЛ УЦК ХХК	205	4
27	100	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ УЦК ХХК	4,861	4
28	501	ГОЛОМТ КАСТОДИАН	6,077	1

Нийт : 457,293 232

Тусгаарлагдсан үнэт цас:

291

Судалгаа гаргасан :  Ж.Нарангэрэл  
Судалгааг хянасан :  Б.Батсүрэн

Анх Шувуун фабрик нэртэйгээр байгуулагдах үеэсээ үржлийн аж ахуйн хэлбэрээр үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд энэ үедээ 30000 толгой шувуу өсгөн бойжуулж, жилдээ 3 сая төгрөгийн борлуулалттай, 2-2.5 сая ширхэг өндөг болон 60-70 тн тахианы мах үйлдвэрлэж байжээ.

Үйл ажиллагаагаа өргтгөтөн 1973 онд ЗХУ-ын техник эдийн засгийн үндэслэлээр 100.000 өндөглөгчтэй болох өргтгөл хийгдсэнээр жилд 22.6 сая ширхэг өндөг, 250 тн тахианы мах үйлдвэрлэх хүчин чадалтай болсон юм. 1990 оны байдлаар гэхэд өдөрт дунджаар 100.000 ширхэг өндөг үйлдвэрлэн, улмаар тухайн ондоо 36.0 сая ширхэг өндөг хүнсний хэрэгцээнд нийлүүлж байсан түүхтэй билээ.

Улмаар 1992.05.01-ний өдрийн МУ-ын Засгийн газрын Өмч Хувьчлалын Комиссын тогтоолоор тус үйлдвэр нь бүрэн хувьчлагдаж Шувууны аж ахуйн "Бөхөг" ХК болон өөрчлөгдөн өнөөг хүртэл үйлдвэрлэлээ тасралтгүй явуулж байна.

2002-2009 онуудад Монгол улсын засгийн газар Чех улсын засгийн газар хоорондын гэрээгээр Чех улсын буцалтгүй тусламжаар тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. Үүнд:

- 60,000 өндөглөгчийн шинэ тоног төхөөрөмж байрлуулсан
- Бага оврын шувуу нядлах тоног төхөөрөмж
- 350 тонн махны чиглэлийн шувуу бойжуулах тоног төхөөрөмж
- Бага оврын инкубаторыг тус тус суурилуулж ашиглалтанд оруулсан.

Одоогийн хүчин чадал: Манай компани тахианы аж ахуйн иж бүрэн шийдэл бүхий 24 объекттой 2011 оны дахин үнэлгээ хийлгэсэнээр зөвхөн үйлдвэрлэлийн байр нь 8,2 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн, эдгээр нь үйлдвэрлэл явуулах бүрэн бололцоо нөхцөлөөр хангагдсан, тоноглогдсон. Бүрэн хүчин чадлаа ашиглан ажиллавал нийтдээ өндөглөгчийн тоог 270 мянганд хүргэхэд хүрэлцэхүйц байртай.

Тус компани 20.0 мянган өндөглөгчийн хүчин чадал бүхий 3 байр ашиглан, жилд дунджаар 18-21 сая ширхэг өндөг үйлдвэрлэж, нэг үдаадаа 40.0 мянган дэгдэхэй бойжуулан өсгөх 2 байр, нэг ээлжиндээ 66,8 мянган өндөг дараах хүчин чадал бүхий 4 инкубатор, 10.0 сая өндөг хадгалах стандартын шаардлага хангасан склад, эргэлтэндээ 250-300 тонн мах хөлдөөн хадгалах хөргүүртэй бөгөөд ээлжиндээ 2.0 мянган толгой шувуу нядлах бага оврын нядалгааны цехийн тоног төхөөрөмж суурилуулан ашиглалтанд оруулсан. Мөн тус бүр нь 360м2 талбай бүхий 6 байранд задгай аргаар махны чиглэлийн дэгдэхэй бойжуулах орчин үеийн технологийн шийдэл бүхий тоног төхөөрөмж суурилагдсан. 2008 онд 40 тн мах үйлдвэрлэн "BBQ" компанийд нийлүүлж байсан. Үүнээс гадна 2000 тонн үр тариа хадгалах элеватор болон хоногт 20 тонн шувууны болон малын төрөл бурийн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай иж бүрэн тэжээлийн цехтэй. Өөрийн гэсэн мал эмнэлэгийн лабораторитойгоороо бусад аж ахуйнуудаас илүү давуу талтай.

Албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот Хан-уул дүүрэг, 13-р хороо, Түүл тосгон өөрийн байрхарт. Утас: 99082693, 452693 болно.

Компанийн удирдлага санхүүгийн тайланг 2023 оны 2-р сарын 10-нд гаргасан.

## 2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

### 2.1 Мөрдсөн стандарт

Санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлгнасан болно.

### 2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон

зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайллангуудыг үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн.

#### 2.3 Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа нь бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртийг сарын жигнэсэн дундаж өртийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

#### 2.4 Үндсэн хөрөнгө

Хайгуул үнэлгээний хөрөнгийг гарсан зардлаар тухай бүр нь бүртгэж ирсэн.

##### Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжсэн.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дунгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ. Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртийг хассан дунг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Газар	Элэгдэл байгуулдаггүй
Барилга байгууламж	10-40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил, компьютер	3-10 жил
Тээрийн хэрэгсэл	10 жил

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

## **2.5 Биет бус хөрөнгө**

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын агаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өргөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 3-аас 5 жил. Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулсанас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

## **2.6 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Тайлант үеийн эцэст биет хөрөнгийн дансны үнийг үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгалтанд хамруулдаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдал (ийм алдагдал гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

## **2.7 Санхүүгийн хөрөнгө**

Санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагаас бүрдэж байна.

### **2.7.1 Зээл ба авлага**

Дансны авлага гэх мэт зарим санхүүгийн хөрөнгө нь дангаараа үнэ цэнийн бууралтанд өртөөгүй гэж үзсэн ч нийт багцын хувьд үнэ цэнийн бууралт явагдсан эсэхийг шалгана. Авлагаа цуглуулдаг туршлага, 30 хоногийн дундаж зээлийн хоногоос хугацаа хэтэрсэн авлагын тоо нийт авлагын багцад өссөн, мөн авлага төлөгдөхгүй, төлбөрийн чадваргүй болж байгаа нь улсын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөлттэй холбоотой байвал авлагын багцын үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо гэж үздэг. Авлагаас бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн хөрөнгийн дансны үнийг бууруулж бүртгэнэ. Худалдааны авлагын хувьд найдвартгүй авлагын сангийн дансаар дамжуулж үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэдэг. Авлагыг цуглуулах найдвартгүй гэж үзвэл авлагыг найдвартгүй авлагын сан руу хааж данснаас хасдаг. Данснаас хассан авлага дараа нь төлөгдвэл найдвартгүй авлагын санд бичсэн бичилтийг буцаана. Найдвартгүй авлагын сангийн дансны үлдэгдлийн өөрчлөлтийг ашиг алдагдалд тусгана.

## **2.8 Санхүүгийн өрийн ба өмчийн хэрэгсэл**

Компанийн гаргаж байгаа өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээнд тусгагдсанаар ямар нөхцөл, бодит байдал үүссэн бөгөөд санхүүгийн өр эсвэл өмчийн хэрэгслийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгсэл гэж ангилдаг.

### **2.8.1 Өмчийн хэрэгсэл**

Хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компани гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Компани өөрийн гаргасан өмчийн хэрэгслийг буцаан худалдан авбал өмчийн хэсгийг бууруулж бүртгэдэг. Өөрийн өмчийн хэрэгслийг худалдан авах, худалдах, гаргах, хүчингүй болгохтой

холбоотойгоор ашиг алдагдлын тайланд олз гарз бүртгэхгүй.

#### 2.8.2 Санхүүгийн өр төлбөр

Гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгадаг. Санхүүгийн өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг өрийн хэрэгслээс бусад санхүүгийн өр төлбөрийг гаргахтай холбоотой гарсан ажил гүйлгээний өргтийг тухайн өр төлбөрийн анхны өртөгт оруулж бүртгэдэг.

Санхүүгийн өр төлбөрийг "бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг" өрийн хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн өр төлбөр гэж хоёр ангилдаг. Санхүүгийн өр төлбөр нь зөвхөн бусад санхүүгийн өр төлбөрөөс бурдэнэ.

#### 2.9 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт, эдгээртэй ижил тестэй хөнгөлөлтуудийг хассан цэвэр дунгээр бүртгэдэг.

#### 2.9.1 Борлуулсан бараа, бүтээгдэхүүн

Хэвийн бизнесийн нөхцөл бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг борлуулалтын буцаалт, худалдааны хөнгөлөлтийг хассаны дараах хүлээн авсан эсвэл хүлээн авах авлагын бодит үнэ цэнээр хэмжинэ. Дараах бүх нөхцөл бүрдсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Барааг эзэмших, өмчлөхтэй холбоотой эрдэл ба өгөөж нь худалдан авагчид шилжсэн;
- Борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй;
- Орлогыг найдвартайгаар хэмжих боломжтой;
- Ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай;
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах зардлуудыг найдвартайгаар хэмжиж, тодорхойлох боломжтой; Ялангуяа, барааг худалдан авагчид хүргэсэн мөн хууль ёсны өмчлөл нь худалдан авагчид шилжсэн үед бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хөнгөлөлт үзүүлэх нь магадлалтай, мөн дүнг нь найдвартайгаар хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрөхдөө уг хөнгөлөлтийг орлогоос хасч бүртгэнэ.

#### 2.10 Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Харин үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт, маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

#### 2.11 Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвараас бурдэнэ.

##### 2.11.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл өдгээр нь огт татвар ногдохгүй

эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Хэвийн бизнесийн үйл ажиллагааны явцад компани нь хууль, эрх зүйн асуудлууд, гомдол нэхэмжлэлд өртөж болно. Ийм хууль, эрх зүйн асуудал, гомдол нэхэмжлэл байгаа бол түүнээс гарах үүрэг хариуцлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд их хэмжээний серөг үр дагаврыг бий болгохгүй гэж удирдлага итгэж байна.

3.1 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Дараах санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

Бараа материалын үнэлгээ

Компанийн удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Эдгээр тооцооллоос хамаарч бараа материалын үнэлгээ өөрчлөгдхөх боломжтой.

Компани нь бараа материалын үнэлгээг тооцоходо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон хувиар тооцдог.

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Тодруулга 9-д тайлбарласнаар, Компанийн үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гаралаагүй.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой. Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

#### 4 Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлagnalын Олон Улсын Стандартууд (СТОУС)

Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2018 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн СТОУС болон өөрчлөлтүүд
	НББОУС 16 болон НББОУС 41-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- Хөдөө Аж Ахуй
	СТОУС 11-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- Хамтарсан үйл ажиллагааны хувь оролцоог олж эзэмшиж үеийн нягтлан бодох бүртгэл
2018 оны 1 сарын 1	НББОУС 16 болон НББОУС 38-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт- Элэгдэл ба хороодлын зохистой аргачлалын ангилал
	НББОУС 1-д хийгдсэн нэмэлт өөрчлөлт - Санхүүгийн тайлангийн толилуулга
	НББОУС 27- д хийгдсэн нэмэлт өөрчлөлт - Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга

СТОУС 10, СТОУС 12 ба НББОУС 28-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж: тайлан бэлтгэхээс чөлөөлсөн нөхцлийг
СТОУС-ын 2012-оос 2014 оны мөчлөгт хийгдсэн Жилийн шинэчлэлүүд

Дээрх стандартын өөрчлөлт болон тайлбарууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад нөлөөлөх хэмжээний өөрчлөлтүүдийг бий болгоогүй бөгөөд санхүүгийн тайланд нөлөөлөөгүй болно.

#### Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол Групп эдгээрийг дагаж мөрднө.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2017 оны 1сарын 1	НББОУС 7-д хийгдсэн өөрчлөлт - Тодруулга
2018 оны 1сарын 1	СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл
	СТОУС 15 Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого
	СТОУС 2-д хийгдсэн өөрчлөлт - Хувьцаанд сууринласан төлбөрийн Хэмжилт болон Ангилал
	СТОУТХ 22 Гадаад валютын гүйлгээ ба урьдчилгаа
	НББОУС 40-д хийгдсэн өөрчлөлт - Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэлт
	СТОУС 15-д хийгдсэн тайлбар Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого

#### Бөхөг ХК САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД 2022 ОН

##### 5. Мөнгө ба түүнтэй адитгах хөрөнгө

	2021	2022
Касс	1,983,187	10,042,187
Мөнгө ба түүнтэй адитгах хөрөнгө	557,413	1,454,713
 Дүн	 2,540,600	 11,496,900

##### 6. Дансны авлага

	2021	2022
авлага	60,690,800	60,690,800
 Дүн	 60,690,800	 60,690,800

##### 7. Бараа материал

	2021	2022
Бараа	141,057,100	141,057,100
 Дүн	 141,057,100	 141,057,100

##### 8. Урьдчилж төлсөн зардал

	2021	2022
Борлуулхаар эзэмшиж буй хөрөнгө	766,278,400	766,278,400
 Дүн	 766,278,400	 766,278,400

**9. Үндсэн хөрөнгө**

	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Нийт дүн
2022.01.01 ҮЛДЭГДЭЛ	798,058,500	2,172,793,000	2,970,851,500
<b>Нэмэгдсэн</b>			
<b>Хасагдсан</b>			
2022.12.31 ҮЛДЭГДЭЛ	798,058,500	2,172,793,000	2,970,851,500
<b>Нэмэгдсэн</b>			
<b>Хасагдсан</b>			
2022.12.31	798,058,500	2,172,793,000	2,970,851,500
<b>Хуримтлагдсан элэгдэл:</b>			
2022 оны 1 сарын 1		(604,840,700)	(604,840,700)
<b>Нэмэгдсэн дүн</b>			
Хасагдсан дүн			
Эцсийн үлдэгдэл 2022.12.31	-	(604,840,700)	(604,840,700)
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН</b>			
Эхний үлдэгдэл	798,058,500	1,567,952,300	2,366,010,800
Эцсийн үлдэгдэл	798,058,500	1,567,952,300	2,366,010,800

**10. Дансны өглөг**

	2021	2022
Төлөгдөх хугацаандаа байгаа	656,499,500	708,911,278
<b>Дүн</b>	656,499,500	708,911,278

**11. Цалингийн өглөг**

	2021	2022
УОО	26,090,600	26,090,600.0
<b>Дүн</b>	26,090,600	26,090,600.0

**12. Богино хугацаат зээл**

	2021	2022
зээл	79,491,700	79,491,700
<b>Дүн</b>	79,491,700	79,491,700

**13. Богино хугацаат өр төлбөр**

	2021	2022
өр төлбөр	833,724,400	833,724,400
<b>Дүн</b>	833,724,400	833,724,400

**14. Татварын өр**

	2021	2022
НӨАТ-н өр	150,638,582	151,353,688
НДШ-н өр	2,265,600	3,417,600
ХХОАТ-н өр	687,918	872,718
Бусад татварын өр	13,161,300	13,161,300
 Дүн	 166,753,400	 168,805,306

**15. Эздийн өмч**

	2021	2022
Энгийн хувьцаа	45,729,300	45,729,300
 Дүн	 45,729,300	 45,729,300

**16. Эздийн өмчийн бусад хэсэг**

	2021	2022
	1,962,373,300	1,962,373,300
 Дүн	 1,962,373,300	 1,962,373,300

**17. Борлуулалтын орлого**

	2021	2022
Түрээсийн орлого	16,800,000	
 Дүн	 16,800,000	

**18. Ерөнхий ба үдирдлагын зардал**

	2021	2022
Цалин ба түүнтэй холбоотой зардлууд	4,800,000	
НДШ -ын зардал	600,000	
Албан татвар төлбөр, хураамжийн зардал	46,376,744	
Зар сурталчилгааны зардал	363,636	
Мэргэжлийн үйлчилгээний хөлс	5,496,213	
Түлш, шатахууны зардал	3,989,091	
Харилцаа холбооны зардал	49,000	
Бусад зардал	632,700	
 Дүн	 -	 62,307,384